МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 16 өдөр Дугаар А/438 Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Боржигон овгийн Самбуугийн Энхтүвшингийн хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/59 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 4 дүгээр хэсэгт иргэн Самбуугийн Энхтүвшин (АЯ67040466)-д эзэмшүүлсэн Мөрөн сумын 13 дугаар баг Улаанбаатар явах засмал зам дагуу байршилтай 6712014907 нэгж талбарын дугаар бүхий аж ахуйн зориулалттай 30000м^2 газраас хувааж иргэн Өлүшкин овгийн Чадраабалын Барсболд (РЭ79041610)-д 10000м^2 газрыг хэсэгчлэн шилжүүлж, үлдсэн 20378м^2 газрыг үлдээн 25 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/59 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 4 дүгээр хэсгийг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар эзэмшигч иргэн С.Энхтүвшин, Ч.Барсболд нартай тус тус газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712014069